

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сагсай сумын Эрүүл мэндийн төсвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БӨА-2022/86/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)  
Өлгий хот  
2023 он

Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,  
тэргүүлэх аудитор: М.Хуанган

Утас: 70422954 Цахим хаяг: khuanganm@audit.gov.mn

Аудитын менежер: Х.Женисбек

Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn

Аудитор: Б.Үүрийнтуяа

Утас: 90832211 Цахим хаяг: uuriintuya.b@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу. .

АГУУЛГА

---

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ .....	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	13
4. АУДИТЫН ТАЙЛАН .....	17
4.1 Ерөнхий зүйл .....	17
4.2 Материаллаг байдал.....	17
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт .....	17
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	17
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	18
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	18
4.5.1 Завсрын аудитын талаар.....	18
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	19
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....	19
5.1 Төлбөрийн акт.....	19
5.2 Албан шаардлага.....	19
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	20

**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын стандарт
ҮАГ	Үндэсний аудитын газар
ЭМДС	Эрүүл мэндийн даатгалын сан
ЭМТ	Эрүүл мэндийн төв

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

  
**БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**  
63129 Өлгий, Баян-Өлгий аймаг  
Утас/Факс: (976) 7042-2954  
E-mail: bayanolgh@audit.gov.mn

2023.02.24 № 264  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

САГСАЙ СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН  
ТӨВИЙН ДАРГА Т.НУРЛАН ТАНАА

### Сөрөг дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сагсай сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн мэдэгдэхүйц нөлөөний улмаас Эрүүл мэндийн төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулаагүй гэж үзсэн.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

1. Жилийн эцсийн эд хөрөнгийн тооллогын бүртгэлийг баримтжуулаагүй, тооллогын дүнгээр хөрөнгө, бараа материалын үлдэгдлийг баталгаажуулаагүй, санхүүгийн тайлан дахь 122.5 сая төгрөгийн бараа материалын үлдэгдлийг тулган баталгаажуулах боломжгүй.

2. Нягтлан бодох бүртгэлийг зохих журмын дагуу хөтлөөгүй, нярвын тооцоог хийгээгүй, нярвын бараа материалын тайлангийн орлого, зарлагын дүн санхүүгийн тайлантай зөрүүтэй байгаа зэрэг нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2, 26 дугаар зүйлийн 26.1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1, 5.1.4, 12 дугаар зүйлийн 12.1, 12.2, 13 дугаар зүйлийн 13.1, 13.7, 18 дугаар зүйлийн 18.1, 20 дугаар зүйлийн 20.2.3, 20.2.6 гэсэн заалтууд болон УСНББОУС 1 стандартуудад нийцэхгүй, иж бүрэн байх, оршин байх, эрх ба үүрэг, толилуулга, батламж мэдэгдлийг хангахгүй байна.

### Асуудлыг онцолсон хэсэг

Санхүүгийн тайлангийн толилуулга, тодруулгыг заавар аргачлалтын дагуу бэлтгэж ирүүлээгүй.

Сагсай сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын гол асуудал**

Өмч хөрөнгийн бүртгэл тооллого, төсвийн хөрөнгийн зарцуулалтад тавих дотоодын хяналтыг хэрэгжүүлээгүй.

**Бусад асуудлын хэсэг**

Эмийн зарцуулалтын тайланг нэгтгэж гаргаагүйгээс орлого, зарлага, үлдэгдлийг баталгаажуулах боломжгүй, Даян хүн эмнэлгийн салбарын хоол, эмийн тооцооны баримтуудыг дутуу ирүүлсэн зэргээр аудитын хамрах хүрээ хязгаарлагдсан.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.



ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР *[Signature]* М.ХУАНГАН

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Төгрөгөөр

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>80,686,464.19</u></b>	<b><u>171,199,522.79</u></b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	984,823.00	48,683,886.03
<b>311</b>	<b>Кассанд байгаа бэлэн мөнгө</b>	-	-
31110	Төгрөг	-	-
31140	Касс арилжааны банк	-	-
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	984,823.00	48,683,886.03
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	984,823.00	48,683,886.03
31211	Төрийн сангийн харилцах	984,823.00	48,683,886.03
31215	Нэмэлт санхүүжилтийн харилцах	-	-
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	18,197,937.00	18,815.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	1,278,698.00	18,815.00
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	16,919,239.00	-
33300	Татаас, санхүүжилтийн авлага	-	-
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	61,503,704.19	122,496,821.76
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	15,618,848.14	88,677,642.76
35130	Эм боох материал	15,618,848.14	88,677,642.76
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	45,884,856.05	33,819,179.00
35410	Бичиг хэргийн материал	10,672,287.00	3,676,269.00
35420	Аж ахуйн материал	19,865,615.00	19,112,850.00
35430	Сэлбэг хэрэгсэл	-	-
35440	Түлш, шатах тослох материал	7,024,710.00	1,250,000.00
35450	Барилгын засварын материал	-	-
35460	Хүнсний материал	8,172,244.05	9,630,060.00
35470	Бусад хангамжийн материал	150,000.00	150,000.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>823,978,545.58</u></b>	<b><u>855,914,572.81</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	823,978,545.58	855,914,572.81
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	806,448,378.93	838,439,406.18
39201	Барилга, байгууламж, орон сууц	822,265,317.00	822,265,317.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(86,379,771.90)	(115,571,652.90)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	66,264,994.00	120,764,994.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(52,675,747.56)	(61,130,996.24)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	82,826,965.05	104,187,685.85
39206	Хуримтлагдсан элэгдэл	(35,797,528.77)	(40,538,546.12)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	27,618,815.00	17,506,375.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(17,782,663.89)	(9,151,770.41)
39214	Бусад үндсэн хөрөнгө	458,000.00	458,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(350,000.00)	(350,000.00)
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	17,530,166.65	17,475,166.63

Сагсай сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

39301	Програм хангамж	550,000.00	550,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(45,833.35)	(100,833.37)
39303	Бусад биет бус хөрөнгө	17,026,000.00	17,026,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	-	-
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>904,665,009.77</u></b>	<b><u>1,027,114,095.60</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b><u>783,860.00</u></b>	<b>=</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	783,860.00	-
<b>413</b>	<b>Өглөг</b>	783,860.00	-
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	-
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	-
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	783,860.00	-
41361	Байгууллагад төлөх өглөг	783,860.00	-
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	-	-
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>903,881,149.77</u></b>	<b><u>1,027,114,095.60</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	903,881,149.77	1,027,114,095.60
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	590,926,695.50	590,926,695.50
51101	Өмч: - төрийн	590,926,695.50	590,926,695.50
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	(238,770,636.70)	(115,537,690.87)
51210	Өмнөх үеийн үр дүн	(259,652,910.48)	(224,776,636.70)
51220	Тайлант үеийн үр дүн	20,882,273.78	109,238,945.83
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	551,725,090.97	551,725,090.97
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>904,665,009.77</u></b>	<b><u>1,027,114,095.60</u></b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>819,408,703.02</b>	<b>929,458,136.89</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>20,593,600.00</b>	<b>72,418,366.09</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	20,593,600.00	72,418,366.09
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	20,593,600.00	72,418,366.09
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	290,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	20,593,600.00	72,128,366.09
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>798,815,103.02</b>	<b>857,039,770.80</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	630,126,736.02	73,510,720.80
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	-
131002	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилт	-	-
131003	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	-
131004	Төсөв болон дамжуулан зээлдүүлсэн зээлээс эргэж төлөгдөх	-	-

Сагсай сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

131005	Хөрөнгийн санхүүжилт	22,095,136.02	73,510,720.80
131006	Засгийн газрын тусгай сангаас санхүүжих	-	-
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	608,031,600.00	-
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>46,415,400.00</b>	<b>-</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	44,820,400.00	
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,595,000.00	-
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>16,628,000.00</b>	<b>29,350,100.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	16,628,000.00	29,350,100.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	<b>105,644,967.00</b>	<b>754,178,950.00</b>
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	105,644,967.00	754,178,950.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>798,526,419.24</b>	<b>820,219,191.06</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>798,526,419.24</b>	<b>820,219,191.06</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>753,726,419.24</b>	<b>813,983,601.06</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>481,523,606.00</b>	<b>475,574,431.35</b>
210101	Үндсэн цалин	439,823,240.00	397,620,030.16
210102	Нэмэгдэл	35,071,145.00	59,777,262.99
210103	Унаа хоолны хөнгөлөлт	6,629,221.00	2,910,000.00
210104	Урамшуулал	-	15,267,138.20
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>70,156,685.00</b>	<b>61,594,770.10</b>
210201	Тэтгэврийн даатгал	49,444,371.00	41,884,443.94
210202	Тэтгэмжийн даатгал	5,178,078.00	4,927,582.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,142,463.00	3,942,066.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,035,615.00	985,515.16
210205	Эрүүл мэндийн даатгал	10,356,158.00	9,855,163.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>14,718,490.00</b>	<b>21,694,857.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	1,914,721.00	3,576,457.00
210302	Түлш, халаалт	12,803,769.00	18,118,400.00
210303	Цэвэр, бохир ус	-	-
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>40,420,470.00</b>	<b>93,744,572.72</b>
210401	Бичиг хэрэг	1,952,820.00	25,988,847.00
210402	Тээвэр, шатахуун	35,808,490.00	62,933,175.72
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,582,660.00	1,511,150.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,076,500.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	3,311,400.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>75,054,682.74</b>	<b>99,568,225.32</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	64,965,241.74	83,215,531.27
210502	Хоол, хүнс	10,059,441.00	15,370,694.05
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	30,000.00	982,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>18,824,632.00</b>	<b>13,214,691.00</b>

Сагсай сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210601	Багаж, техник, хэрэгсэл	18,458,001.00	8,555,191.00
210604	Урсгал засвар	366,631.00	4,659,500.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>1,660,000.00</b>	<b>1,327,400.00</b>
210701	Гадаад албан томилолт	-	-
210702	Дотоод албан томилолт	1,660,000.00	1,327,400.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>945,856.00</b>	<b>820,120.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	376,100.00	-
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	300,000.00	300,000.00
210803	Даатгалын үйлчилгээ		94,120.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	167,600.00	104,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	220,000.00
210807	Газрын төлбөр	101,200.00	102,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	<b>956.00</b>	
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>50,421,997.50</b>	<b>46,444,533.57</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,120,110.00	2,519,840.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	48,301,887.50	-
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	-	43,924,693.57
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>44,800,000.00</b>	<b>6,235,590.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>44,800,000.00</b>	<b>-</b>
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	44,800,000.00	-
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>-</b>	<b>6,235,590.00</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	6,235,590.00
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>-</b>	<b>-</b>
220001	Барилга байгууламж	-	-
221001	Их засвар	-	-
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b><u>20,882,283.78</u></b>	<b><u>109,238,945.83</u></b>
<b>145</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН</b>	<b>-</b>	<b>-</b>
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	-	-
145002	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олз	-	-
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>-</b>	<b>-</b>
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	-
225002	Найдваргүй авлагын алдагдал	-	-
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b><u>20,882,283.78</u></b>	<b><u>109,238,945.83</u></b>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Төгрөгөөр

Сагсай сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b><u>759,800,728.00</u></b>	<b><u>797,813,050.00</u></b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	-	<b>290,000.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	-	290,000.00
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	-	290,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		-
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	290,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>759,800,728.00</b>	<b>797,523,050.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	608,031,600.00	-
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	608,031,600.00	-
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>46,415,400.00</b>	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	44,820,400.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,595,000.00	-
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>16,628,000.00</b>	<b>29,350,100.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	16,628,000.00	29,350,100.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	<b>88,725,728.00</b>	<b>768,172,950.00</b>
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	88,725,728.00	768,172,950.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b><u>695,145,768.00</u></b>	<b><u>747,763,986.97</u></b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>695,145,768.00</b>	<b>747,763,986.97</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>695,145,768.00</b>	<b>741,528,396.97</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	496,223,628.00	478,924,805.97
210101	Үндсэн цалин	317,185,920.00	308,840,200.00
210102	Нэмэгдэл	130,516,409.00	121,010,953.97
210103	Унаа хоолны хөнгөлөлт	7,322,167.00	6,592,446.00
210104	Урамшуулал	41,199,132.00	42,481,206.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>56,444,657.00</b>	<b>57,115,993.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	40,380,490.29	39,244,088.88
210202	Тэтгэмжийн даатгал	3,960,505.58	4,533,392.96
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,168,405.27	3,568,642.59
210204	Ажилгүйдлийн даатгал	785,707.62	925,297.28
210205	Эрүүл мэндийн даатгал	8,149,548.24	8,844,571.29
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>15,518,500.00</b>	<b>22,144,857.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	1,914,731.00	2,494,057.00
210302	Түлш, халаалт	13,603,769.00	19,650,800.00
210303	Цэвэр, бохир ус		
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>41,896,163.00</b>	<b>66,225,288.00</b>
210401	Бичиг хэрэг	3,534,703.00	4,748,293.00
210402	Тээвэр, шатахуун	35,676,800.00	54,990,900.00

Сагсай сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,949,260.00	1,510,400.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	735,400.00	432,400.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	4,543,295.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>64,267,850.00</b>	<b>100,908,664.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	47,125,850.00	75,025,700.00
210502	Хоол, хүнс	14,830,000.00	16,702,964.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,312,000.00	9,180,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>14,567,130.00</b>	<b>9,482,559.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	13,457,630.00	6,501,686.00
210604	Урсгал засвар	1,109,500.00	2,980,873.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>2,590,000.00</b>	<b>1,327,400.00</b>
210702	Дотоод албан томилолт	2,590,000.00	1,327,400.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>1,022,590.00</b>	<b>820,120.00</b>
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	300,000.00	300,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	140,000.00	94,120.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	67,000.00	104,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	29,390.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	220,000.00
210807	Газрын төлбөр	101,200.00	102,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>2,615,250.00</b>	<b>4,578,710.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,615,250.00	4,578,710.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>-</b>	<b>6,235,590.00</b>
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>-</b>	<b>6,235,590.00</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг		6,235,590.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b><u>64,654,960.00</u></b>	<b><u>50,049,063.03</u></b>
<b>4</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)</b>	<b>-</b>	<b>-</b>
140001	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого		
140002	Улсын төсвөөс олгосон зээл		
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>-</b>	<b>2,350,000.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>-</b>	<b>2,350,000.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>-</b>	<b>2,350,000.00</b>
220001	Барилга байгууламж		
221001	Их засвар		
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	-	2,350,000.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>=</b>	<b><u>(2,350,000.00)</u></b>
14	<b>Бусад эх үүсвэр</b>	<b>-</b>	<b>-</b>
145004	Дотоод эх үүсвэрээс олгосон зээлээс эргэж төлөгдөх		

Сагсай сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

145005	Дамжуулан зээлдүүлэх зээлээс эргэж төлөгдөх		
25	<b>Санхүүгийн үйл ажиллагааны зардал</b>	-	-
250002	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө		
250003	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн		
7	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	≡	≡
8	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	64,654,960.00	47,699,063.03
9	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	-	984,823.00
10	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	984,823.00	48,683,886.03

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

**Төгрөгөөр**

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2019 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	590,926,695.50	551,725,090.97	(238,770,636.70)	903,881,149.77
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	590,926,695.50	551,725,090.97	(238,770,636.70)	903,881,149.77
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				-
C07	Тайлант үеийн үр дүн				-
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	590,926,695.50	551,725,090.97	(238,770,636.70)	903,881,149.77
D01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	590,926,695.50	551,725,090.97	(238,770,636.70)	903,881,149.77
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			13,994,000.00	13,994,000.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	590,926,695.50	551,725,090.97	(224,776,636.70)	917,875,149.77
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				-
D08	Тайлант үеийн үр дүн			109,238,945.83	109,238,945.83
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	590,926,695.50	551,725,090.97	(115,537,690.87)	1,027,114,095.60

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

**Төгрөгөөр**

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>795,370,700.00</b>	<b>743,878,396.97</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>795,370,700.00</b>	<b>743,878,396.97</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>795,370,700.00</b>	<b>743,878,396.97</b>
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	486,515,100.00	478,924,805.97
210101	Үндсэн цалин	308,840,200.00	308,840,200.00
210102	Нэмэгдэл	125,653,100.00	121,010,953.97
210103	Унаа хоолны хөнгөлөлт	9,540,000.00	6,592,446.00
210104	Урамшуулал	42,481,800.00	42,481,206.00

Сагсай сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>62,064,300.00</b>	<b>57,115,993.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	42,203,800.00	39,244,088.88
210202	Тэтгэмжийн даатгал	4,965,100.00	4,533,392.96
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,972,100.00	3,568,642.59
210204	Ажилгүйдлийн даатгал	993,000.00	925,297.28
210205	Эрүүл мэндийн даатгал	9,930,300.00	8,844,571.29
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>25,741,100.00</b>	<b>22,144,857.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	3,637,100.00	2,494,057.00
210302	Түлш, халаалт	22,104,000.00	19,650,800.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>68,847,800.00</b>	<b>66,225,288.00</b>
210401	Бичиг хэрэг	5,333,700.00	4,748,293.00
210402	Тээвэр, шатахуун	54,990,900.00	54,990,900.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,590,800.00	1,510,400.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	432,400.00	432,400.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,500,000.00	4,543,295.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>109,112,300.00</b>	<b>100,908,664.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	75,025,700.00	75,025,700.00
210502	Хоол, хүнс	17,508,600.00	16,702,964.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	16,578,000.00	9,180,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>25,011,600.00</b>	<b>11,832,559.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	19,361,200.00	8,851,686.00
210604	Урсгал засвар	5,650,400.00	2,980,873.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>1,327,400.00</b>	<b>1,327,400.00</b>
210702	Дотоод албан томилолт	1,327,400.00	1,327,400.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>995,000.00</b>	<b>820,120.00</b>
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	360,000.00	300,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	140,000.00	94,120.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	140,000.00	104,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	253,000.00	220,000.00
210807	Газрын төлбөр	102,000.00	102,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>15,756,100.00</b>	<b>4,578,710.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	15,756,100.00	4,578,710.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	-	-
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	-	-
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал		
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	-	-
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	-	-
220001	Барилга байгууламж		
221001	Их засвар		
<b>13</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>795,370,700.00</b>	<b>791,577,460.00</b>

Сагсай сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	29,350,100.00	23,114,510.00
132001	Орон нутгийн төсвөөс	29,350,100.00	23,114,510.00
<b>1340</b>	<b>НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	747,966,100.00	751,393,273.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	747,966,100.00	751,393,273.00
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	18,054,500.00	17,069,677.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	18,054,500.00	18,054,500.00
<b>4</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		984,823.00
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	-	48,683,886.03
<b>6</b>	<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>		
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>1</b>	<b>1</b>
610001	Төсвийн байгууллага	1	1
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>32</b>	<b>34</b>
620001	Удирдах ажилтан	1	1
620002	Гүйцэтгэх ажилтан	25	26
620003	Үйлчлэх ажилтан	6	7
620004	Гэрээт ажилтан		
<b>65</b>	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>32</b>	<b>34</b>
650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	26	27
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	6	7

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

##### *Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар*

Сагсай сумын Эрүүл мэндийн төв нь Эрүүл мэндийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2, 16.7-д заасан үндсэн чиг үүрэг болон эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан чиг үүргүүдийг хэрэгжүүлж ажилладаг.

Тайлант онд “Орон нутгийн хүн амд үзүүлэх эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээг өрхийн анагаах ухаанд үндэслэн цогц байдлаар хүргэж, тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх” зорилго дэвшүүлэн ажилласан байна.

Дээрх зорилгыг биелүүлэхээр дараах зорилтуудыг дэвшүүлэн ажилласан байна. Үүнд:

- Эрүүл мэндийн төвөөр үзүүлж байгаа эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүрээг өргөтгөх, чанарыг сайжруулах
- Сагсай сумын эрүүл мэндийн төвийн санхүүжилтийн механизмыг боловсронгуй болгох, нэмэгдүүлэх
- Эрүүл мэндийн төвийн бүтэц, зохион байгуулалтыг оновчтой болгох
- Эрүүл мэндийн төвийн хүний нөөцийн чадавхыг нэмэгдүүлэх, тогтвор суурьшилтай ажиллуулах

- Хяналт шинжилгээ, үнэлгээний тогтоолцоог бүрдүүлж нотолгоонд тулгуурласан мэдээ, мэдээллийг төлөвлөлт хийхэд ашиглах чадавхыг бүрдүүлэх

### **3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин**

#### ***Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар***

Сагсай сумын Эрүүл мэндийн төв нь Эрүүл мэндийн тухай хууль, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хууль болон бусад эрүүл мэндийн байгууллагуудад мөрдөж байгаа бусад хууль тогтоомжуудыг үйл ажиллагаандаа мөрдөж ажилласан байна.

Тайланд хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна.

Тайлант оноос үйл ажиллагааны хувьсах зардлыг Эрүүл мэндийн даатгалын сангаас гүйцэтгэлээр санхүүжүүлэх тогтолцоонд шилжиж, санхүүгийн тайлангаа Эрүүл мэндийн яаманд нэгтгэлд тушаадаг болсон байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын албанаас сургуулийн 2020-2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, 5.2 сая төгрөгийн акт тогтоож, зөрчил арилгах 1 албан шаардлага өгөгдсөн байна.

Дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сагсай сумын Эрүүл мэндийн төв 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

#### ***Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар***

Сагсай сумын Эрүүл мэндийн төв нь Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулж ажиллаагүй байна.

### **3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд**

Сагсай сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Сагсай сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 122.4 сая төгрөгөөр буюу 13.5 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	984.8	48,683.9	47,699.1
Авлага	18,197.9	18.8	(18,179.1)
Урьдчилгаа			-
Бараа материал	61,503.7	122,496.8	60,993.1
Үндсэн хөрөнгө	823,978.5	855,914.6	31,936.0
<b>Нийт хөрөнгө</b>	<b>904,665.0</b>	<b>1,027,114.1</b>	<b>122,449.1</b>
Өр төлбөр	783.9	-	(783.9)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	903,881.1	1,027,114.1	123,232.9
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>904,665.0</b>	<b>1,027,114.1</b>	<b>122,449.1</b>

Эх сурвалж: Аудитын судалгаа

Мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөр, засгийн газрын хувь оролцоо дансуудад өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна.

Мөнгөн хөрөнгийн данс оны эцэст 48.7 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарсан нь цалингийн зардлыг 7.6 сая, НДШ-ийн зардлыг 4.9 сая, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 3.6 сая, хангамж, бараа материалын зардлыг 2.6 сая, нормативт зардлыг 8.2 сая, эд хогшил, урсгал засварын зардлыг 13.2 сая, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлыг 0.2 сая, бараа үйлчилгээний бусад зардлыг 11.2 сая төгрөгөөр тус тус хэмнэсэн, эрүүл мэндийн даатгалын сангаас 48.0 сая төгрөгийн санхүүжилтийг илүү олгосонтой холбоотой байна.

Авлага данс оны эхэнд 18.2 сая төгрөгийн үлдэгдэлтэй байсан бол оны эцэст 18.2 сая төгрөгөөр буурч 0.02 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарсан байна. Эрүүл мэндийн даатгалын сангаас авах 13.9 сая, нийгмийн даатгалын шимтгэлийн 1.3 сая төгрөгийн авлагатай байснаас санхүүжилтийн авлагыг барагдуулж, тайлант онд нийгмийн даатгалын шимтгэлийн 0.02 сая төгрөгийн авлагыг шинээр үүсгэсэн байна.

Бараа материалын данс 61.0 сая төгрөгөөр нэмэгдсэн нь аймгийн ЭМГ-аас 59.8 сая төгрөгийн эмийг үнэ төлбөргүй хүлээн авсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгийн данс 31.9 сая төгрөгөөр нэмэгдсэн нь төсвийн хөрөнгөөр 2.4 сая, үнэ төлбөргүй 73.5 сая төгрөгийн хөрөнгө хүлээн авч, элэгдлээ нөхсөн 10.1 сая төгрөгийн хөрөнгийг акталж, үндсэн хөрөнгөнд тайлант онд 43.9 сая төгрөгийн элэгдэл байгуулсантай холбоотой байна.

Өр төлбөр данс оны эхэнд 0.8 сая төгрөгийн үлдэгдэлтэй байсныг барагдуулж ажилласан байна.

Тайлант онд 123.2 сая төгрөгийн үр дүнтэй ажилласантай холбоотой Засгийн газрын хувь оролцоо данс 123.2 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг Эрүүл мэндийн даатгалын сангаас 863.9 сая, орон нутгийн төсвөөс 24.0 сая, нийт зарлагыг 887.9 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Дээд шатны төсвийн захирагчаас төсвийг хянаж 766.0 сая төгрөгөөр баталсан байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд 748.0 сая төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын сангаас, 29.5 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс бүрдүүлэхээр, туслах үйл ажиллагааны орлогоос 18.1 сая төгрөгөөр тусгасан байна.

Гүйцэтгэлээр Эрүүл мэндийн даатгалын сангаас 751.4 сая төгрөгийн, орон нутгийн төсвөөс 29.4 сая төгрөгийн санхүүжилт олгож, туслах үйл ажиллагааны орлогоос 18.1 сая төгрөгөөр бүрдүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 743.9 сая төгрөг буюу 93.5 хувьтай байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

Д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
<b>1</b>	<b>71601-Нийгмийн эрүүл мэнд</b>				
	80112-Нийтлэг үйлчилгээ	29,350.10	23,114.50	(6,235.60)	78.8
<b>2</b>	<b>71602-Эмнэлгийн тусламж үйлчилгээ</b>			-	
	80302-Нэг иргэнд ноогдох нормативаар	460,939.10	436,379.30	(24,559.80)	94.7
	81603-Үндсэн мэргэжлийн тусламж, үйлчилгээ	287,027.00	266,347.10	(20,679.90)	92.8
	83603-Дээд шатны төсвөөс хуваарилсан	18,054.50	18,037.50	(17.00)	99.9
	<b>Дүн</b>	<b>795,370.70</b>	<b>743,878.40</b>	<b>(51,492.30)</b>	<b>93.5</b>

*Эх сурвалж: Аудитын судалгаа*

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Эрүүл мэндийн яамнаас нэмэлт төсвийн дансыг хаах чиглэл ирүүлж, 2022 онд дээд шатны төсвөөс хуваарилсан санхүүжилт нь үндсэн дансанд тусдаа арга хэмжээ болж орж ирсэн байна.

### 3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Сагсай сумын Эрүүл мэндийн төв 2022 онд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

---

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Сагсай сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах хууль тогтоомжийн хэрэгжилт, бүртгэл тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Үүрийнтуяа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, дарга, тэргүүлэх аудитор М.Хуанган нар тус тус хэрэгжүүлсэн.

Сагсай сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайланг 2023 оны 1 дүгээр сарын 31-ны өдрийн 02 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Сагсай сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 597.5 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 8.9 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй үзсэн.

### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тайлант оны батлагдсан төсвийг нийт дүнгээр 51.5 сая төгрөгөөр хэмнэж зарцуулсан байна. Эрүүл мэндийн төв нь тайлант онд цалингийн зардлыг 7.6 сая, НДШ-ийн зардлыг 4.9 сая, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 3.6 сая, хангамж, бараа материалын зардлыг 2.6 сая, нормативт зардлыг 8.2 сая, эд хогшил, урсгал засварын зардлыг 13.2 сая, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлыг 0.2 сая, бараа үйлчилгээний бусад зардлыг 11.2 сая төгрөгөөр тус тус хэмнэлттэй зарцуулжээ. Хэмнэлтээс 6.2 сая төгрөгийн орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг шалгахад дараах алдаа, зөрчил илрээгүй.

### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх

дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны мэдээллээс программд орсон мэдээллүүдийн хэрэгжилтийг шалгав.

Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 19.7 сая төгрөгийн зарлагын 3 мөнгөн гүйлгээг зарцуулалт гарсныг шилэн дансанд мэдээлээгүй байна. Шилэн дансанд мэдээлсэн байдлын хэрэгжилтийн хувь 75% байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгасан дүнгээр зөвлөмж өгөв.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудит хийгдээгүй.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар жилийн эцсийн эд хөрөнгийн тооллогын бүртгэлийг баримтжуулаагүй, тооцоо хийж үлдэгдлийг баталгаажуулаагүй, үндсэн хөрөнгө, бараа материалын үлдэгдлийг тулган баталгаажуулах боломжгүй. Санхүүгийн тайлан дахь бараа материалын эхний үлдэгдэл нярвын материалын тайлангаарх эхний үлдэгдлээс 22.8 сая төгрөгөөр, эцсийн үлдэгдэл 19.1 сая төгрөгөөр, жилийн эцсийн тооллогын дүнгээс 26.9 сая төгрөгөөр, Үндсэн хөрөнгийн дүн, тооллогын дүнгээс 42.1 сая төгрөгөөр зөрүүтэй. Эмийн 15.6 төгрөгийн үлдэгдлийн тооллогын баримтыг аудитын хугацаанд ирүүлээгүй, өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар хөрөнгийн бүртгэл, тайлагналтай холбоотой өгөгдсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, зөрчлийг давтан гаргасан. Нягтлан бодох бүртгэлийн заавал хөтлөх журнал, дэлгэрэнгүй болон ерөнхий данс бүртгэлийг хөтлөөгүй зөрчлийг арилгаж ажиллаагүй.

Аудитаар хэрэгжилтийг давтан шалгахад өмнөх зөрчлийг давтан гаргасан 0.0%-ийн биелэлттэй байна. Шилэн данстай холбоотой алдаа, зөрчлийг давтан гаргасан байна.

Хүснэгт 4. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт					
Албан шаардлага	1	595,378.0	0	0	0

Зөвлөмж					
Нийт дүн	1	595,378.0	0	0	0

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

#### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 819.4 сая төгрөгийн алдаа<sup>1</sup> илэрснээс аудитын явцад 819.4 сая төгрөгийн алдааг залрууллаа. Үүнд:

- Үр дүнгийн тайланд ЭМД-ын сангаас авсан санхүүжилтийг 13.9 сая төгрөгөөр илүү тайлагнасан,
- Актлах шийдвэр гараагүй байхад элэгдлийн хугацаа нь дууссан 10.1 сая төгрөгийн тавилга эд хогшлыг балансаас хасаж тайлагнасан,
- Төсвийн гүйцэтгэлийн тайланд төлөвлөгөө, гүйцэтгэлийг 795.4 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасныг аудитын явцад холбогдох тайлангуудад залруулсан.

Аудитаар 305.4 сая төгрөгийн зөрчил илэрч 2.7 сая төгрөгийн акт тогтоож, 302.7 сая төгрөгийн албан шаардлага, 1 заалттай зөвлөмж өгөв. Үүнээс төвийн дарга, нягтлан бодогчид хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлсэн.

##### 5.1 Төлбөрийн акт

*Аудитын дүнгээр дараах зөрчилд төлбөрийн акт тогтоосон. Үүнд:*

1. Төвийн дарга, нягтлан бодогч нар нь 2022 онд сахилгын шийтгэлтэй байсан хугацааны үр дүнгийн урамшуулалд нийт 2,099.2 мянган төгрөгийг төсвөөс үндэслэлгүй хууль бусаар авсан.

2. Ажиллагсдын цалингаас нийтдээ 33,272.0 мянган төгрөгийн цалингийн ашгийн татварыг суутган авч 32,692.8 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлж, 579.2 мянган төгрөгийг татварыг төсөв төвлөрүүлээгүй, санхүүгийн тайланд өглөгөөр тусгаж харуулаагүй байна.

##### 5.2 Албан шаардлага

*Аудитын дүнгээр дараах зөрчилд албан шаардлага өгөв. Үүнд:*

1. Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 19.7 сая төгрөгийн 3 мөнгөн гүйлгээг шилэн дансанд мэдээлээгүй, шилэн дансанд мэдээлсэн байдлын хэрэгжилтийн хувь 75% байна.

*Аудитаар дараах зөрчилд сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага хүргүүлсэн. Үүнд:*

1. Төвийн даргын 2022 оны А/19 дугаар тушаалаар байгуулагдсан жилийн эцсийн эд хөрөнгийн тооллого хийх ажлын хэсэг тооллогын бүртгэлийг хөтөлсөн боловч тооллогын дүнг хэлэлцэж үндсэн хөрөнгө болон 122,496.8 мянган төгрөгийн бараа материалын үлдэгдлийн тооллогын бүртгэлийг баримтжуулаагүй, нягтлан бодогч нь тооллогын дүнгээр тооцоо хийж үлдэгдлийг баталгаажуулаагүй.

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

2. Анхны өртгөө элэгдлээрээ бүрэн нөхсөн, ашиглах хугацаа нь дууссан 10,112.4 мянган төгрөгийн тавилга эд хогшлыг актлах санал хүргүүлсэн бөгөөд эрх бүхий байгууллагын тогтоол шийдвэр гараагүй байхад балансаас хасаж тайлагнаж ирүүлсэн.

3. Санхүүгийн тайланд үнэ төлбөргүй хүлээн авсан 1855.7 мянган төгрөгийн хөрөнгийг дутуу, 59,840.0 мянган төгрөгийн үнэ төлбөргүй эм, эмнэлгийн хэрэгслийг орлогын падаанаар тулгаж орлогод аваагүйгээс тооцоо хийх боломжгүй. Жилийн эцэст 88,677.6 мянган төгрөгийн эмийн үлдэгдэлтэй боловч эмийн зарцуулалтын тайланг нэгтгэж гаргаагүйгээс үлдэгдлийг баталгаажуулах боломжгүй, Даян хүн эмнэлгийн салбарын хоол, эмийн тооцоо дутуу ирүүлснээс тооцоо хийж боломжгүй.

4. Нярвын эм, тээвэр шатахуун, хоолны бараа материалын тайлан дахь орлого, зарлагын дүн болон Мөнгөн гүйлгээний тайлан, Үр дүнгийн тайлан дахь орлого, зарлагын дүнгүүд хоорондоо зөрүүтэй, санхүүгийн тайлан гаргахдаа нярвын тайланг үндэслээгүй. Нягтлан бодох бүртгэл хөтлөлт, санхүүгийн тайлагналын талаар өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлүүдийг давтан гаргасан байна.

### 5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### 1. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

##### 1.1. Илрүүлэлт:

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиггүй, удирдлага болон нягтлан бодогч нь санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар ойлголт, мэдээлэлгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.9-д "нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг" гэж бүртгэлийн суурь, санхүүгийн тайлан гаргахад баримтлах зарчмыг тодорхойлсон журам, заавар, аргачлалыг багтаасан баримт бичгийг", 18 дугаар зүйлийн 18.2-т "Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана" гэсэн заалттай нийцээгүй, АОУС-250-д "Санхүүгийн тайланд хууль тогтоомж, дүрэм, журмыг анхаарах", УСНББОУС-1, АДБОУС 200 болон нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

##### 1.2. Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн хэрэгжилтийн хангаж нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулж санхүү, бүртгэл, тайлагналын үйл ажиллагаандаа ашиглах, байгууллагын удирдлага, нягтлан бодогч нар санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаарх мэдээлэл, ойлголтоо сайжруулах;

Дээрх зөвлөмжүүдийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2023 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа	Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан	Буруу тусган илэрхийлсэн	/мянган төгрөгөөр/		Зөвлөмж
				Үүнээс Залруулсан	Залруулаагүй	

Сагсай сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Үр дүнгийн тайланд ЭМД-ын сангаас авсан санхүүжилтийг 13.9 сая төгрөгөөр илүү тайлагнасан	1	13,944.0			1	13,944.0	1	13,944.0				
Актлах шийдвэргүйгээр хөрөнгийг балансаас хассан	1	10,112.4			1	10,112.4	1	10,112.4				
Төсвийн гүйцэтгэлийн тайланд санхүүжилт, зөрүүтэй тайлагнасан	1	795,370.70			1	795,370.70	1	795,370.70				
<b>Дүн</b>	<b>3</b>	<b>819,427.1</b>			<b>3</b>	<b>819,427.1</b>	<b>3</b>	<b>819,427.1</b>				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	/мянган төгрөгөөр/ Үүнээс											
	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгуулл агад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Төвийн дарга, нягтлан бодогч нар нь сахилгын шийтгэлтэй байхад 2,099.2 мянган төгрөгийн урамшуулал авсан, 579.2 мянган төгрөгийн татварыг төсөв төвлөрүүлээгүй, санхүүгийн тайланд өглөгөөр тусгаж харуулаагүй	1	2,678.4	1	2,678.4								
Өмнөх аудитаар илэрсэн зөрлийг давтан гаргасан, албан үүргээ хэрэгжүүлээгүй	2	282,982.6							2	282,982.6		
НББ-ийн бодлогын баримт бичиггүй	1	0.0					1	0.0				
<b>Дүн</b>	<b>4</b>	<b>285,661.00</b>	<b>1</b>	<b>2,678.4</b>			<b>1</b>	<b>0.0</b>	<b>2</b>	<b>282,982.6</b>		

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	/мянган төгрөгөөр/ Үүнээс									
	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн

Сагсай сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 19.7 сая төгрөгийн зарлагын 3 мөнгөн гүйлгээг мэдээлээгүй					1	19,721.7		
<b>Дүн</b>					<b>1</b>	<b>19,721.7</b>		
Төрийн хэмнэлтийн тухай хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
<b>Нийт дүн</b>					<b>1</b>	<b>19,721.7</b>		